АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ АУДИТ

**АУДИТЫН КОД:**

**АРА-2023/12/-1-ШТА-ТД**


Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Алтантуяа
Утас: 70333019 Цахим хаяг: altantuyan@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ
Утас: 7033-3019 Цахим хаяг: tsogerdeneg@audit.gov.mn
Ахлах аудитор П.Цэцэгдулам
Утас: 7033-3019 Цахим хаяг: tsetsegdulamp@audit.gov.mn



ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2023 ОН


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

## АГУУЛГА


АГУУЛГА ... 1

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ ... 3

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ ... 4

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ : ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦСЭН БОЛОВЧ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛААГҮЙ БАЙНА ... 7

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨСВИЙН ОРЛОГЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР БАТЛАГДСАН ХЭМЖЭЭНД ТӨЛӨВЛӨСӨН БӨГӨӨД ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА ... 8

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР БАТЛАГДСАН ХЭМЖЭЭНД ТӨСӨВ ЗАХИРАГЧ БҮРЭЭР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА ... 14

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДСАН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТИЙН 81.6 ХУВЬ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА ... 17

ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 75.7 ХУВЬ БАЙНА ... 21

АУДИТЫН ДҮГНЭЛТ ... 22

ЗӨВЛӨМЖ: ... 22

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ... 24

БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ ... 25

| **Тайлан бэлтгэсэн:**<br>Архангай аймаг дахь<br>Төрийн аудитын газар | ➢ **Товчилсон үгийн тайлбар**<br>➢ **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй** |
|---|---|
| **Тэргүүлэх аудитор**<br>**Т.Байгалмаа**<br><br>**Аудитын менежер**<br>**Д.Нэргүйбаатар**<br><br>**Ахлах аудитор**<br>**Н.Алтантуяа**<br>**Г.Цог-Эрдэнэ**<br>**П.Цэцэгдулам**<br><br>2023 оны 11 дүгээр сар<br>Уг тайланг<br>www.audit.mn сайтаас үзнэ үү.<br><br>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033-3141 дугаарын факсаар харилцана уу<br><br>Хаяг:<br>Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр<br>3-р давхар 314 тоот | **БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦСЭН БОЛОВЧ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛААГҮЙ БАЙНА**<br><br>**БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ОРЛОГЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР БАТЛАГДСАН ХЭМЖЭЭНД ТӨЛӨВЛӨСӨН БӨГӨӨД ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА.**<br><br>**БҮЛЭГ 3: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР БАТЛАГДСАН ХЭМЖЭЭНД ТӨСӨВ ЗАХИРАГЧ БҮРЭЭР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА**<br><br>**БҮЛЭГ 4: ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДСАН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТИЙН 81.6 ХУВЬ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА**<br><br>**ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 75.7 ХУВЬ БАЙНА**<br><br>Дүгнэлт.......................................................................................<br>Зөвлөмж .....................................................................................<br>Тайлан баталгаажуулсан тушаал.............................................<br>Хавсралт:Судалгаанууд .........................................................<br><br>**Хүснэгтийн товьёг**<br>Хүснэгт №1 Орон нутгийн 2024 оны төсвийн орлого, зарлагын тэнцэл<br>Хүснэгт №2 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, зарцуулах төсөв<br>Хүснэгт №3 Орон нутгийн орлогын харьцуулсан судалгаа<br>Хүснэгт №4 Татварын болон татварын бус орлого<br>Хүснэгт №5 Хадгаламжийн хүүгийн орлогын татварын тооцоолол<br>Хүснэгт №6 Харьцуулалт судалгаа<br>Хүснэгт №7 Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл<br>Хүснэгт №8 Харьцуулалт судалгаа<br>Хүснэгт №9 Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл<br>Хүснэгт №10 Цалингийн өсөлтийн судалгаа<br>Хүснэгт №11 Харьцуулалт судалгаа<br>Хүснэгт №12 Хүргүүлсэн төсвийн санал ба батлагдсан суурь зарлагын судалгаа<br>Хүснэгт №13 Зарлагын харьцуулалт<br>Хүснэгт №14 Төсөвт байгууллагуудад хуваарилсан байдал<br>Хүснэгт №15 Төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл<br>Хүснэгт №16 Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал<br>Хүснэгт №17 Төсөвлөлтийн шаардлага хангасан эсэх мэдээлэл<br>Хүснэгт №18 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ<br>Дүрслэлийн товьёг 1 Санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн судалгаа<br>Дүрслэлийн товьёг 2 Аймгийн 2024 оны төсвийн орлогыг өмнөх онуудтай харьцуулалт<br>Дүрслэлийн товьёг 3 Нийт зардлын дунд эзлэх хувь<br>Дүрслэлийн товьёг 4 ХО-ын төсөл арга хэмжээний эх үүсвэр |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| **АДБОУС** | *Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт* |
| **МУ** | *Монгол Улс* |
| **УИХ** | *Улсын Их Хурал* |
| **ЗГ** | *Засгийн газар* |
| **ИТХ** | *Иргэдийн төлөөлөгчдийн хурал* |
| **ТЕЗ** | *Төсвийн ерөнхийлөн захирагч* |
| **ЗДТГ** | *Засаг даргын тамгын газар* |
| **СТСХ** | *Санхүү төрийн сангийн хэлтэс* |
| **ХОХБТХ** | *Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс* |
| **БОАЖГ** | *Байгаль орчин аялал жуулчлалын газар* |
| **ОНӨГ** | *Орон нутгийн өмчийн газар* |
| **СХАА** | *Санхүүгийн хяналт, аудитын алба* |
| **ГХБХБГ** | *Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар* |
| **ХТҮГ** | *Хот тохижилт үйлчилгээний газар* |
| **ХААГ** | *Худалдан авах ажиллагааны газар* |
| **ЭМТ** | *Эрүүл мэндийн төв* |
| **ОНХС** | *Орон нутгийн хөгжлийн сан* |
| **ОНТХО** | *Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт* |
| **ТАХ** | *Төсөл арга хэмжээ* |
| **ХХОАТ** | *Хувь хүний орлогын албан татвар* |
| **ХБГ** | *Хүлээгдэж буй гүйцэтгэл* |
| **ТЭЗҮ** | *Техник эдийн засгийн үндэслэл* |
| **ОНӨААТҮГ** | *Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар* |
| **ГХУСЗ** | *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал* |
| **ЗДНХ** | *Засаг даргын нөөц хөрөнгө* |

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:** Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын ”Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/04 дугаар тушаалын дагуу гүйцэтгэлээ.

**Аудитын зорилго:** Орон нутгийн төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитын ерөнхий зарчим, зорилго, хамрах хүрээ, арга хандлага, шалгах зүйл, шалгуур үзүүлэлтийг стандартад нийцсэн, хараат бус байдлыг хангасан үр нөлөө бүхий дүгнэлт, зөвлөмж гаргахыг зорьж ажиллалаа.
Архангай аймгийн 2024 оны орон төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ-д хүргүүлэн, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ. Энэ зорилготой холбоотой дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөж гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг холбогдох хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх
- Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд орлогын саналыг хууль тогтоомжид заасны дагуу иж бүрэн, бодитой тооцож төлөвлөсөн эсэх
- Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд зарлагын саналыг хууль тогтоомжид заасны дагуу иж бүрэн, бодитой тооцож төлөвлөсөн эсэх
- Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байхаар төлөвлөсөн эсэх

**Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:** Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1: 2020 Төрийн аудитын тулгуур зарчим, MNS 6817 -5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан ”Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “ Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ыг мөрдөж ажиллав.
Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлалыг гол шалгуур болголоо.

**Аудитын хамарсан хүрээ:** Аудитын явцад Архангай аймгийн 2023 оны төсөв, төсвийн тодотгол, хүлээгдэж байгаа гүйцэтгэл, аймгийн Засаг даргаас Сангийн яаманд хүргүүлсэн 2024 оны жилийн төсвийн төсөл, Сангийн Яамнаас хянаж ирүүлсэн тооцоо, холбогдох мэдээлэл, аймгийн ЗДТГ-ын СТСХ болон ХОХБТХ, БОАЖГ, Татварын хэлтэс, сумдын татварын байцаагч болон төсвийн орлого бүрдүүлдэг зарим байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, орлого, зардал, төсөвтэй холбоотой тайлан, мэдээ, судалгаа, өмнөх онуудын аудитын тайлан, аймгийн ИТХ-д хүргүүлсэн санал дүгнэлт зэрэгт үндэслэн нөхцөл байдлыг тодорхойлон дүн шинжилгээ хийв.

**Талуудын хүлээх үүрэг, хариуцлага:** Аймгийн Засаг дарга нь жилийн төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, Төрийн аудитын байгууллагад жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор хүргүүлж, аймгийн ИТХ-д өргөн

мэдүүлэх үүрэгтэй. Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн Орон нутгийн төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Аудитын бүрэлдэхүүн:** Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Алтантуяа, П.Цэцэгдулам, Г.Цог-Эрдэнэ нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

**Хүндрэл бэрхшээл:** Аймгийн Засаг дарга нь жилийн төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, Төрийн аудитын байгууллагад жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор хүргүүлж, аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэх үүрэгтэй. Төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг Төсвийн тухай хуульд заасан 5 хоногийн хугацаанд гүйцэтгэдэг байдал нь мэдээллийг иж бүрэн шинжлэх, дүгнэлт гаргах зэрэг аудитын үйл ажиллагаа хязгаарлагддаг юм.
Мөн шалгагдагч байгууллагуудаас төсвийн төслийг иж бүрэн ирүүлээгүй, аудитын явцад шаардлагатай нэмэлт мэдээлэл, судалгаа, тооцоо, холбогдох баримт бичгүүдийг аудитын явцад нэмж ирүүлж байгаа нь аудитыг хугацаанд нь гүйцэтгэхэд хүндрэл учруулж байлаа.

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн төсвийн орлого 2023 оны 10 дугаар сарын байдлаар 16,353.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 2,092.3 сая төгрөгөөр нэмэгдсэн, орон нутгийн төсвийн зарлага 40,095.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй нь өмнөх оны мөн үеэс 7,661.3 сая төгрөгийн өссөн үзүүлэлттэй үзүүлэлттэй байна. /аймгийн нийгэм эдийн засгийн байдал статистик эмхэтгэл -2023.10 сар /

*Орон нутгийн 2024 оны төсвийн төслийн тооцооллыг Сангийн яамнаас Төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсэн удирдамжийн дагуу бэлтгэн онлайнд суурилсан FISCAL-B системд зардлын эдийн засгийн ангилал, зориулалт, арга хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрээр оруулж, судалгааны хамт Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлжээ. Төсвийн санал суурь орлогыг 14,338.1 сая төгрөг, зарлагыг 46,726.3 сая төгрөгөөр төсөвлөсөн байна.*

Монгол Улсын Их Хуралд 2023 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны Төсвийн төсвийн төсөл, 2024 оны төсвийн тухай хуулиар 2024 оны төсвийн жилд Архангай аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 36,330.5 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 12,118.9 сая төгрөгөөр тусгасныг УИХ-аар батлахдаа санхүүгийн дэмжлэгээс 10.5 сая төгрөгийг бууруулан баталжээ
Санхүүгийн дэмжлэг, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг өмнөх онтой харьцуулан авч үзвэл: санхүүгийн дэмжлэг 18,814.1 сая төгрөгөөр, орлогын шилжүүлэг 3,538.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд нийт орлого 70,296.1 сая төгрөг үүнээс 20,218.7сая төгрөг нь орон нутгийн төсвийн орлого, 18.5 сая төгрөг нь ТЕЗ түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого, 36,320.0 сая төгрөг нь улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг, 12,118.9 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг, 80.0 сая төгрөг нь цэргийн дүйцүүлэх албаны урьд оны үлдэгдэл, 40.0 сая төгрөг нь мал хамгаалах сангийн орлогууд байна.

*/ Дүрслэл № 1 /*




Орон нутгийн 2024 оны төсвийн орлого, зарлагын тэнцэл дараах байдалтай байна.

Хүснэгт №1

| | |
|---|---|
| **Орон нутгийн нийт орлого, санхүүгийн дэмжлэгийн дүн** | **70,296.1** |
| **Орон нутгийн орлого** | 20,218.7 |
| **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | 18.5 |
| **Санхүүгийн дэмжлэг** | 36,320.0 |
| **Урьд оны төсвийн үлдэгдлээс /мал хамгаалах сан, цэргийн дүйцүүлэх алба/** | 120.0 |
| **ОНХС-ийн шилжүүлэг** | 12,118.9 |
| **ОНХС-ийн урьд оны төсвийн үлдэгдэл** | 1,500.0 |
| **Орон нутгийн зарлагын дүн** | **70,296.1** |
| **Сумын удирдлагын салбарын дүн** | 20,838.4 |
| **Аймгийн удирдлагын салбарын дүн** | 19,937.6 |
| **Халамжийн сангийн дүн** | 117.7 |
| **ОНХСанд зарцуулах** | 16,435.0 |
| **Орон нутгийн байгууллагын тогтмол зардал / Боловсрол, соёл, эрүүл мэнд /** | 12,927.4 |
| **Мал хамгаалах сан** | 40.0 |

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх...” гэж заасны дагуу аймгийн Засаг даргаас 2024 оны төсвийн төслийг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01/1722 тоот албан бичгээр ирүүлсэн. Төсвийн төслийг төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т заасан тайлбар, танилцуулга, тооцоо, хавсралтуудыг иж бүрэн ирүүлээгүйг аудитын явцад зарим хэсгийг гаргуулан авсан болно.

Аймгийн Засаг даргын орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд аудитыг холбогдох баримт материал, тооцоо судалгаанд үндэслэн орлого нэмэгдүүлэх, төсвийн үр ашгийг дээшлүүлэх аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг дараах бүлгүүдэд тусган танилцуулж байна.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ : ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦСЭН БОЛОВЧ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛААГҮЙ БАЙНА

Монгол улсын их хурлаас 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Монгол улсын 2024 оны төсвийн тухай хууль болон бусад дагалдах хууль УИХ-ын тогтоол батлагдсан. Төсвийн тухай хууль тогтоомж батлагдсантай холбогдуулан УИХ, Засгийн газраас 2024 онд баримталсан төсвийн бодлого чиглэлийг орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд тусган боловсруулж, ИТХ-аар батлуулах, баталсан төсвийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлсийг чиглэл болгон ирүүлсэн.

2024 оны Аймгийн төсөв нь Монгол Улсын Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлого, хот хөдөөгийн сэргэлт, аймгийг хөгжүүлэх таван жил, жилийн төлөвлөгөө, бусад хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээнүүд, төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, орон нутагт төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллаж төрийн үйлчилгээг саадгүй хүртээмжтэй хүргэх, иргэдийн ая тухтай амьдрах орчин бүрдүүлэх, хот суурингийн тохижилтыг сайжруулах, ногоон байгууламж, хог хаягдлын менежментийг сайжруулах, төр өөрийн зардлаа хэмнэх, оновчтой байдлаар дахин хуваарилах, төрийн үйлчилгээг цахимжуулах зэргээр бүх шатны төсвийн байгууллагууд хэмнэлтийн горимоор ажиллах Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлийг баримтлахаар тусгасан байна.

*А.1.1* Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг 159 төсөв захирагчдын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр боловсруулсан бөгөөд нийт 12 хөтөлбөр, 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 70,296.1 сая төгрөг төсөвлөсөн байна.

Хүснэг№2 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, зарцуулах төсөв /сая төгрөг/

| Салбарын чиглэл | Байгууллагын тоо | Хэрэгжүүлэх | | зарцуулах төсөв /сая.төг/ |
|---|---|---|---|---|
| | | хөтөлбөрийн тоо | арга хэмжээний тоо | |
| Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа | 20 | 1 | 4 | 4,497.1 |
| Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 20 | 1 | 5 | 49,542.5 |
| Санхүү хяналт | 1 | 1 | 2 | 429.7 |
| Төрийн өмч, худалдан авах эрхийг хэрэгжүүлэх | 2 | 1 | 1 | 623.9 |
| Хөдөө аж ахуй, газар тариалан аж үйлдвэр | 1 | 1 | 1 | 1,481.9 |
| Хүрээлэн буй орчин | 4 | 2 | 5 | 1,782.6 |
| Барилга хот байгуулалт нийтийн аж ахуй | 1 | 1 | 4 | 994.7 |
| Эрүүл мэнд | 20 | 1 | 1 | 1,858.7 |
| Соёл урлаг спорт, аялал жуулчлал | 24 | 1 | 1 | 2,863.6 |
| Боловсрол шинжлэх ухаан | 65 | 1 | 1 | 6,103.7 |
| Нийгмийн хамгаалал | 1 | 1 | 2 | 117.7 |
| **Нийт дүн** | **159** | **12** | **27** | **70,296.1** |

Аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн төсөлд тусгагдсан 57 төсөл арга хэмжээ нь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 зорилттой агуулгын хувьд нийцэж байна. Харин аймгийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө батлагдаагүй байна.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг батлаагүй, жилийн эцсийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байгаа тухай аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн 113 тоот албан бичгээр хариу ирүүлсэн нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор батална” гэж заасантай нийцэхгүй байна.

- Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д заасан хугацаанд батлаж байх зөвлөмжийг аймгийн ИТХ-д хүргүүллээ.

- Төсвийн төсөл нь Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу иж бүрэн ирээгүй тул төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 67 дугаар зүйлийн 67.2, Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар баталсан Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д заасан шаардлагын дагуу бүрэн ирүүлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

*А.1.3* Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/302 дугаар захирамжаар 2024 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг олон нийтийн оролцоотой төсвийг төлөвлөх, иргэдээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулжээ. Ажлын хэсгээс 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээнд Соёл, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, тариаланчдын нээлттэй форумуудыг зохион байгуулж оролцогчдоос давхардсан тоогоор 620 саналыг авч нэгтгэсэн байна. Мөн 19 сумын ЗДТГ, аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, агентлаг байгууллагуудаас санал авч нэгтгэн хэрэгцээ шаардлагад нь үндэслэн эрэмбэлж төсвийн төсөлд тусган ажилласан байна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨСВИЙН ОРЛОГЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР БАТЛАГДСАН ХЭМЖЭЭНД ТӨЛӨВЛӨСӨН БӨГӨӨД ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА.

***Б.2.1*** *Орон нутгийн 2024 оны төсвийн орлогыг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн дагуу татварын 19 нэр төрөл, татварын бус 4 нийт 23 нэр төрлийн орлогын хүрээнд төлөвлөсөн байна. Нийт орлогын 60%-ийг цалин хөлсний албан татвар эзэлж байна.*

***Б.2.2*** *Төсвийн орлогын тооцооллыг холбогдох байгууллагын санал, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулжээ*

Аймгийн Засаг даргаас төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төслийг боловсруулах удирдамж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам зааврын хүрээнд орон нутгийн орлогын төсвийн төслийг боловсруулахдаа сумдаас ирүүлсэн төсвийн төсөл, мэргэжлийн байгууллагууд, газар

хэлтсүүдээс ирүүлсэн холбогдох тооцоо судалгааг нэгтгэж, орон нутгийн төсвийн суурь орлогыг 14,338.1 сая төгрөгөөр боловсруулан Сангийн Яаманд хүргүүлжээ. /хүснэгт-

Хүснэгт № 3 Орон нутгийн орлогын харьцуулсан судалгаа сая төгрөг

| Үзүүлэлтийн нэр | Орон нутгаас хүргүүлсэн 2024 оны орлогын төсвийн төсөл | | Сангийн Яам хянасан | | Суурь орлогын зөрүү | Өсөлт бууралтын хувь | Аймгийн ИТХ-аар батлагдах |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Суурь орлого | Нийт орлого | Суурь орлого | Нийт орлого | | | |
| 1.НИЙТ ОРЛОГО | 14,338.1 | 14,872.2 | 17,421.1 | 17,861.9 | 3,083.0 | 121.5 | 20,237.2 |
| 2.УРСГАЛ ОРЛОГО | 14,338.1 | 14,872.2 | 17,421.1 | 17,861.9 | 3,083.0 | 121.5 | 20,237.2 |
| 3.ТАТВАРЫН ОРЛОГО | 12,773.2 | 13,307.3 | 15,347.5 | 15,788.3 | 2,574.3 | 120.2 | 18,163.7 |
| 4.Орлогын албан татвар | 9,812.6 | 9,812.8 | 11,849.9 | 11,850.1 | 2,037.3 | 120.8 | 11,850.1 |
| Хүн амын орлогын албан татвар | 9,812.6 | 9,812.8 | 11,849.9 | 11,850.1 | 2,037.3 | 120.8 | 11,850.1 |
| Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах орлогын албан татвар | 8,623.7 | 8,623.7 | 10,440.0 | 10,440.0 | 1,816.3 | 121.1 | 10,440.0 |
| Үйл ажиллагааны орлого | 542.8 | 542.8 | 570.0 | 570.0 | 27.2 | 105.0 | 570.0 |
| Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа хөдөлмөр эрхлэгч хувь хүний ОАТ | 8.1 | 8.2 | 8.2 | 8.4 | 0.1 | 101.9 | 8.4 |
| Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/ | 1,306.4 | 1,306.4 | 1,500.0 | 1,500.0 | 193.6 | 114.8 | 1,500.0 |
| Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого | 216.7 | 216.7 | 216.7 | 216.7 | - | 100.0 | 216.7 |
| Шууд бус орлого | 15.0 | 15.0 | 15.0 | 15.0 | - | 100.0 | 15.0 |
| ХХОАТ буцаалт | (900.0) | (900.0) | (900.0) | (900.0) | - | 100.0 | (900.0) |
| ААНОАТ | 971.5 | 971.5 | 1,060.0 | 1,060.0 | 88.5 | 109.1 | 1,060.0 |
| Өмчийн татвар | 722.1 | 1,084.4 | 807.0 | 1,089.2 | 84.9 | 111.8 | 3,464.6 |
| Малын тоо толгойн албан татвар | - | - | - | - | - | - | 2,375.4 |
| Үл хөдлөх хөрөнгийн татвар | 291.8 | 542.1 | 350.0 | 542.2 | 58.2 | 120.0 | 542.2 |
| Бууны албан татвар | 76.5 | 76.5 | 77.0 | 77.0 | 0.5 | 100.6 | 77.0 |
| Авто тээвэр өөр явагч хэрэгслийн албан татвар | 353.8 | 465.8 | 380.0 | 470.0 | 26.2 | 107.4 | 470.0 |
| Бусад татвар | 956.4 | 1,090.1 | 1,167.0 | 1,287.6 | 210.6 | 122.0 | 1,287.6 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 207.8 | 225.1 | 249.0 | 260.0 | 41.2 | 119.8 | 260.0 |
| Газрын төлбөр | 221.8 | 338.3 | 369.0 | 478.6 | 147.2 | 166.3 | 478.6 |
| -----Газрын төлбөр | 200.8 | 317.3 | 208.2 | 317.8 | 7.4 | 103.7 | 317.8 |
| ------Газрын дуудлага худалдааны орлого | 21.0 | 21.0 | 160.8 | 160.8 | 139.8 | 765.7 | 160.8 |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 38.5 | 38.5 | 60.0 | 60.0 | 21.5 | 155.8 | 60.0 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 488.2 | 488.2 | 489.0 | 489.0 | 0.8 | 100.2 | 489.0 |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр: | 310.6 | 348.4 | 463.6 | 501.5 | 153.0 | 149.3 | 501.5 |
| -------Байгалийн ургамал ашигласны төлбөр | 1.6 | 1.6 | 1.6 | 1.6 | 0.0 | 100.6 | 1.6 |
| ------- Ус рашааны нөөц ашигласны төлбөр | 52.6 | 90.4 | 80.0 | 117.9 | 27.4 | 152.2 | 117.9 |
| -------Ойн нөөц ашигласны төлбөр | 240.0 | 240.0 | 365.0 | 365.0 | 125.0 | 152.1 | 365.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| --------Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 16.4 | 16.4 | 17.0 | 17.0 | 0.6 | 103.6 | 17.0 |
| 5.ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,544.9 | 1,544.9 | 2,053.6 | 2,053.6 | 508.7 | 132.9 | 2,053.6 |
| Төсөвт газрын өөрийн орлого | 18.5 | 18.5 | 18.5 | 18.5 | - | 100.0 | 18.5 |
| Торгуулийн орлого | 1,176.4 | 1,176.4 | 1,176.4 | 1,176.4 | - | 100.0 | 1,176.4 |
| Нэр заагдаагүй бусад орлого | 350.0 | 350.0 | 350.0 | 350.0 | - | 100.0 | 350.0 |
| Хүүгийн орлого | - | - | 508.7 | 508.7 | 508.7 | 0.0 | 508.7 |
| ХӨРӨНГИЙН ОРЛОГО | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 | - | 100.0 | 20.0 |
| Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 | - | 100.0 | 20.0 |

Сангийн яамнаас суурь орлогыг нэмэгдүүлэх чиглэлийг баримтлан нийт дүнгээр **21.5** хувь буюу **3,083.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэн хянасан байна. Өндөр дүнгээр нэмэгдүүлсэн зарим нэр төрлийн орлогыг авч үзвэл:

- Цалин хөлсний орлогын албан татварыг 2024 онд төрийн албан хаагчдын үндсэн цалинг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 21.1 хувь буюу **1,816.3** сая төгрөгөөр,
- Хадгаламжийн хүүгийн орлогын татварыг 14.8 хувиар буюу **193.6** сая төгрөгөөр,
- Газрын дуудлага худалдааны орлогыг 665.7 хувь буюу **139.8** сая төгрөгөөр,
- Ойн нөөц ашигласны төлбөрийг / самрын орлого / 52.1 хувиар буюу **125.0** сая төгрөгөөр,
- Үл хөдлөх хөрөнгийн татварыг 20.0 хувиар буюу **58.2** сая төгрөгөөр,
- Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлттэй холбоотой хүүгийн орлогыг **508.7** сая төгрөгөөр нэмэгдүүлэн хянасан байна.

Аймгийн ИТХ-аар батлуулах 2024 оны орон нутгийн төсвийн орлогод Сангийн Яамнаас хянасан суурь орлого 17,421.1 сая төгрөг дээр малын тоо толгойн албан татварын 2,375.4 сая төгрөг, нийт болон суурь орлогын зөрүүгээр үл хөдлөх хөрөнгийн албан татвар 192.2 сая төгрөг, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар 90.0 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 11.0 сая төгрөг, газрын төлбөр 109.6 сая төгрөг, ус рашааны нөөц ашигласны төлбөр 37.9 сая төгрөг нийт 440.7 сая төгрөг нэмэгдэж, аймгийн төсвийн орлогыг **20,237.2** сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Аймгийн 2024 оны төсвийн орлогыг өмнөх онуудтай харьцуулан авч үзвэл: *Дүрслэл 2*




Нийт орлогод татварын орлогын эзлэх хувь 2020 онд 87.4%, 2021 онд 91.8%, 2023 онд 82.3

, 2024 онд 89.7 хувийг эзэлсэн байна. Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө жил бүр өсч байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 8.2 хувиар өссөн байна.

## ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

### ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГЫГ 777.1 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА

Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас орон нутгийн 2024 оны төсвийн орлогыг аудитын явцад цуглуулсан нотлох баримт материалд үндэслэн дараах 3 нэр төрлийн орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс нийт 777.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүргүүлж байна. Үүнд:

Хүснэгт № 4 Татварын болон татварын бус орлого /сая төгрөг/

| № | Орлогын нэр | Сангийн яамны хянасан дүн | Аудитын боломжит санал | Нэмэгдүүлэх хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | Хадгаламжийн хүүгийн орлогоос тооцох татварын орлого | 1,500.0 | 1,600.0 | 100.0 |
| 2 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого болон түрээсийн орлого | 20.0 | 62.2 | 42.2 |
| 3 | Цалин хөлсний орлогын албан татвар | 10,440.0 | 11,074.9 | 634.9 |
| Нийт дүн | | **11,960.0** | **12,737.1** | **777.1** |

Орлогын нэр төрлөөр дэлгэрэнгүй тооцооллын хамт танилцуулбал:

**I. Хадгаламжийн хүүгийн орлогоос тооцох татварын орлогыг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх**

**Аймгийн Монгол банкны мэдээллээс үзэхэд 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар аймгийн арилжааны банкин дахь** хадгаламжийн үлдэгдэл 155,038.3 сая төгрөг байсан байна. Харин 2023 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар хадгаламж 164,763.9 сая төгрөг болж өмнөх оноос 6.2 хувиар өсжээ. Монгол банкны Архангай салбараас аймгийн хэмжээний хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийн үлдэгдэл, жигнэсэн дундаж хүүгийн судалгааг 2023 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар гаргуулан авч, судалгаанд үндэслэн орлогын тооцооллыг хийхэд хадгаламжийн хүүгийн орлогын албан татвараас 1,775.5 сая төгрөг төвлөрөх тооцоолол байна.

Хүснэгт № 5 /сая төгрөг/

| Хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ | | Нийт хадгаламжийн дүн | Хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж хувь хэмжээ | | Хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж хувь хэмжээгээр тооцсон дүн | | Нийт хадгаламжийн хүүгийн орлогын дүн жигнэсэн дундаж хүүгийн хувь хэмжээгээр тооцсон дүнгээр | ХХОАТ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хугацаатай хадгаламж | Хугацаагүй хадгаламж | | Хугацаатай хадгаламж | Хугацаагүй хадгаламж | Хугацаатай хадгаламж | Хугацаагүй хадгаламж | | |
| 1 | 2 | 3=1+2 | 4 | 5 | 6=1*4 | 7=2*5 | 8=6+7 | 9=8*10% |
| 138,881.8 | 25,882.1 | 164,763.9 | 12.3% | 2.6% | 17,082.5 | 672.9 | 17,755.4 | 1,775.5 |

(2023 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар ирүүлсэн Монгол банкны Архангай салбарын мэдээгээр хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү-12.3%, хугацаагүй хадгаламж 2.6% байгааг үндэслэн тооцов. Монгол банкны Архангай салбараас ирүүлсэн 2023.11.17-ны А-30/147 тоот албан бичиг, дэлгэрэнгүй судалгааг хавсралт 1-ээс үзнэ үү)

Сангийн Яамнаас хадгаламжийн хүүгийн орлогын албан татварыг **1,500.0** сая төгрөгөөр хянасан бөгөөд аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн орон нутгийн 2024 оны төсвийн

төслийн тооцоо судалгаагаар **1,708.0** сая төгрөгийг төвлөрүүлэх тооцоог хийжээ.
Тус орлогын тооцоог 2024 оны орон нутгийн орлогын төсвийн төсөл, Сангийн Яамнаас хянасан дүнтэй уялдуулан авч үзвэл:

Хүснэгт №6 /Сая төгрөг/

| 2024 оны орон нутгийн орлогын төсвийн төсөлд тусгасан дүн | Сангийн Яамнаас хянасан дүн | Татварын хэлтсээс ирүүлсэн санал | Аудитаар төвлөрөх боломжтой дүн | Нэмэгдүүлэх санал |
|---|---|---|---|---|
| **1,306.4** | 1,500.0 | 1,708.0 | 1,600.0 | **100.0** |

Иймд аудитаас дээрх тооцоо судалгаа, 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, өмнөх оноос нийт хадгаламжийн хэмжээ өссөн байдал, Татварын хэлтсээс ирүүлсэн тооцоо зэргийг харгалзан орлогыг **100.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэн **1,600.0** сая төгрөг болгон төлөвлөх саналыг гаргаж байна.

## II. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого болон түрээсийн орлогыг 42.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх

Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого гүйцэтгэлээр 2021-2023 онуудад 195.2-599.3%-иар давж биелсэн байна. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр авч үзвэл:

Хүснэгт № 7 /сая төгрөгөөр/

| 2021 он | | | 2022 он | | | 2023 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Төлөвлөгөө** | Гүйцэтгэл | Давсан + тасарсан - | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Давсан + тасарсан - | Төлөвлөгөө | Гүйцэтгэл /2023 оны эхний 10 сар / | Хүлээгдэж буй гүйцэтгэл |
| **15.0** | 89.9 | 74.9 | 31.4 | 109.4 | 78.0 | 50.0 | 97.6 | 98.0 |

Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн 2024 оны төсвийн төслийн төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны болон түрээсний орлоготой холбоотой тооцоо, судалгааг авч үзэхэд:

- 2023 онд орон нутгийн өмчид бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө буюу ашиглалтгүй байгаа 12 барилгыг хувьчилж хөрөнгө борлуулсны орлогыг 22.8 сая төгрөгөөр,
- Булган хангай хорооллын дулааны шугам сүлжээний түрээсийн гэрээгээр эзэмшүүлж, гэрээний төлбөрийг 16.4 сая төгрөгөөр,
- Тариат сумын төвийн шинэчлэлийн шугам сүлжээний түрээс орлогыг 13.0 сая төгрөг,
- Орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийг дуудлага худалгаагаар борлуулсны орлогыг 10.0 сая төгрөг, нийт 62.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх тооцоо байна.

2024 оны орон нутгийн орлогын төсвийн төсөл, Сангийн Яамнаас хянасан дүн, ирүүлсэн саналыг уялдуулан авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №8 /сая төгрөг/

| 2024 оны орон нутгийн орлогын төсвийн төсөлд тусгасан дүн | Сангийн Яамнаас хянасан дүн | Орон нутгийн өмчийн газрын санал | Аудитаар төвлөрөх боломжтой дүн | Нэмэгдүүлэх санал |
|---|---|---|---|---|
| **20.0** | 20.0 | 62.2 | 62.2 | **42.2** |

Аудитаас 2024 оны орон нутгийн орлогын төсвийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого болон түрээсийн орлого бүрэн төвлөрөх боломжтой гэж үзэн Сангийн Яамны хянасан дүнг **42.2** сая төгрөгөөр нэмэгдүүлж, **62.2** сая

төгрөгөөр төлөвлөх саналыг гаргаж байна. /*Эх сурвалж: ОНӨГ-ын 2023 оны 10 дугаар сарын 27-ны 454 тоот албан бичиг/*

### III. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах орлогын албан татварын орлогыг 634.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах орлогын албан татвар 2021-2022 онд 113.3-126.2 хувиар биелсэн. Харин 2023 оны ХБГ-ээр 100.6 хувиар давж биелэх мэдээг ирүүлсэн. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 3 жилээр авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №9 /сая төгрөг/

| 2021 он | | | 2022 он | | | 2023 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Төлөвлөгөө** | Гүйцэтгэл | Давсан + тасарсан - | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Давсан + тасарсан - | Төлөвлөгөө | Гүйцэтгэл /2023 оны эхний 10 сар / | Хүлээгдэж буй гүйцэтгэл |
| **5,400.0** | 6,120.2 | 720.2 | 5,800.0 | 7,318.3 | 1,518.3 | 8,328.8 | 7,487.2 | 8,385.8 |

2023 онд төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор хүлээгдэж буй гүйцэтгэлээр төлөвлөгөө 107.8%-аар давж биелэх тооцоо гарч байна.

Төрийн албан хаагчдын үндсэн цалингийн өсөлтийн тооцоог Засгийн Газрын 2022 оны 107, 488 дугаар тогтоол болон 2023 оны 241 дүгээр тогтоолтой нийцүүлэн үзлээ.

Хүснэгт № 10

| Албан тушаалын зэрэглэл, ангилал | Өсөлтийн хувь |
|---|---|
| Засгийн Газрын 2022.12.28-ны өдрийн 488 дугаар тогтоол болон 2023.06.21-ны өдрийн 241 дүгээр тогтоолыг харьцуулахад: | |
| ТЗ | 52.5 |
| ТТ | 37.9 |
| ТҮ | 31.5 |
| Засгийн Газрын 2022.03.09-ны өдрийн 107 дугаар тогтоол болон 2023.06.21-ны өдрийн 241 дүгээр тогтоолыг харьцуулахад: | |
| ТҮБД | 51.1 |
| ТҮЭМ | 49.0 |
| ТУСУ | 65.4 |
| Нийт дундаж хувь | **47.9** |

2023 оны 10 дугаар сарын байдлаар төрийн албан хаагчдын үндсэн цалин дунджаар 2022 болон 2023 эхний хагас жилийн түвшнээс 47.9 хувиар нэмэгдсэн дүнтэй байна.

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах орлогын албан татварыг аймгийн Татварын хэлтсээс 2022, 2023 оны суурь бааз, тооцоо судалгааны хүрээнд 8,623.9 сая төгрөгөөр төлөвлөж Сангийн Яаманд хүргүүлснийг 21.0 хувь буюу 1,816.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 10,440.0 сая төгрөгөөр хянасан байна.

**2024 оны тухайд** : Монгол улсын төсвийн тухай хууль болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар дараах шийдвэрүүд гарсан. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023.10.13-ны өдрийн 12 дугаар тогтоолоор 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг одоогийн түвшнээс 20.0 хувиар нэмэгдүүлэн 660.0 мянган төгрөг болгон баталсан.
- Монгол Улсын Их хурлаар 2024 оны төсөвт төрийн албан хаагчдын цалинг 2024.04.01-нээс 10 хувиар нэмэгдүүлэхээр баталсан.

Аудитаас 2024 оны төсвийн тухай хуулийг үндэслэн 2024 оны 4 дүгээр сарын 1-нээс цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах орлогын албан татварыг 574.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцлоо. */тооцооллыг хавсралт 3-аас үзнэ үү/*

Мөн 2024 онд УИХ -ын болон аймаг, сумдын ИТХ-ын сонгуультай холбогдуулан сонгуулийн хороонд ажиллах төрийн албан хаагчдын урамшуулал хоолны зардлыг 2020 оны жишгээр тооцоход ХХОАТ-аар 60.0 сая төгрөг төсөвт төвлөрөх боломжтой байна.

Тус орлогын тооцоог, Сангийн Яамнаас хянасан дүнтэй уялдуулан авч үзвэл:

Хүснэгт №11 / сая төгрөг/

| **2024 оны орон нутгийн орлогын төсвийн төсөлд тусгасан дүн** | **Сангийн Яамнаас хянасан дүн** | **Аудитаар төвлөрөх боломжтой дүн** | **Нэмэгдүүлэх санал** |
|---|---|---|---|
| **8,623.7** | 10,440.0 | 11,074.9 | **634.9** |

Иймд тус орлогыг Сангийн Яамнаас 10,440.0 сая төгрөгөөр хянасныг 634.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 11,074.9 сая төгрөг болгон батлах саналыг гаргаж байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР БАТЛАГДСАН ХЭМЖЭЭНД ТӨСӨВ ЗАХИРАГЧ БҮРЭЭР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

*B.3.1* Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсөл боловсруулах журам”-ын дагуу орон нутгийн төсөвт байгууллагуудын 2024 оны төсвийн төслийг холбогдох маягтын дагуу хүлээн авч хянан Сангийн Яамнаас ирүүлсэн ТЕЗ нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж чиглэлийн дагуу нэмэлт тооцооллуудыг хийж, төсвийн урсгал зардлыг төсөв захирагч бүрээр төлөвлөсөн байна.

Орон нутгийн 2024 оны төсвийн зарлагын саналыг нийт **46,726.7** сая төгрөгөөр төлөвлөн Сангийн Яаманд хянуулахаар хүргүүлснийг **7,014.8** сая төгрөгөөр буюу 15.0 хувиар нэмэгдүүлэн хянаж, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тухай хуулиар аймгийн төсвийн зарлагыг **53,741.1** сая төгрөгөөр баталсан байна.

Хүргүүлсэн төсвийн санал ба батлагдсан суурь зарлагын дүнг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт№12 /сая төгрөгөөр/

| Код | Зардлын ангилал | 2024 оны төсвийн зарлагын санал | 2024 он Сангийн Яам хянасан | Зөрүү | Өсөлт бууралтын хувь |
|---|---|---|---|---|---|
| **24** | ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГАА | 46,726.3 | 53,741.1 | 7,014.8 | 115.0 |
| **2** | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 46,726.3 | 53,741.1 | 7,014.8 | 115.0 |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 46,726.3 | 50,232.8 | 3,506.5 | 107.5 |
| **210** | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 44,785.0 | 47,123.8 | 2,338.8 | 105.2 |
| **2101** | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 19,557.2 | 20,153.2 | 596.0 | 103.0 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,750.8 | 2,519.2 | -231.6 | 91.6 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 12,732.4 | 12,925.3 | 192.9 | 101.5 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 1,483.6 | 768.7 | -714.9 | 51.8 |
| **2105** | Нормативт зардал | 531.5 | 494.2 | -37.3 | 93.0 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,252.0 | 1,404.7 | -847.3 | 62.4 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 484.9 | 283.3 | -201.6 | 58.4 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,558.3 | 7,804.6 | 4,246.3 | 219.3 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,434.3 | 770.6 | -663.7 | 53.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **211** | Хүү | 0.0 | 508.7 | 508.7 | - |
| **212** | ТАТААС | 25.0 | 358.1 | 333.1 | 1432.4 |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,916.3 | 2,242.2 | 325.9 | 117.0 |
| **22** | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.0 | 3,508.3 | 3,508.3 | - |
| **3** | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 46,726.3 | 53,741.1 | 7,014.8 | 115.0 |
| **31** | Улсын төсвөөс санхүүжих | 46,726.3 | 53,741.1 | 7,014.8 | 115.0 |
| **35** | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 0.0 | 18.5 | 18.5 | - |

Хүснэгтээс харахад цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, хүү, татаас, урсгал шилжүүлэг зэрэг зардлыг 1.5 - 1332.4 хувиар нэмэгдүүлэн хянасан нь Монгол Улсын ЗГ-ын хэрэгжүүлж буй бодлого шийдвэртэй холбоотой байна. Тухайлбал:

- Хот хөдөөгийн сэргэлт, шинэ сэргэлтийн бодлогыг хүрээнд төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор орон нутгийн нэмэгдэл олгох, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг олгох, төрийн албан хаагчдын цалинг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэхээр төсөвт тусгасан,
- Мөн хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт бодлогын хүрээнд хөрөнгийн зардлыг өмнөх оноос нэмэгдүүлж, ЗГ-ын дэд хөтөлбөрүүд болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардал зэргийг төсөвт тусган хянажээ.

*Дүрслэл 3*




Сангийн Яамнаас хянасан төсвийн зарлагыг зардлын эдийн засгийн ангиллаар авч үзвэл: Нийт зардлын 42.0 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 42.0 хувийг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 24.0 хувийг, бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардал 14.0 хувийг, бусад урсгал зардлууд 9.0 хувийг, хөрөнгийн зардал 7.0 хувийг, урсгал шилжүүлэг, тэтгэмж 4.0 хувийг эзэлж байна.

*В.3.2* Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг Сангийн Яамнаас хянаж, Аймгийн ИТХ-аар батлуулахаар ирүүлсэн төсвийн төсөлтэй харьцуулан авч үзвэл:

Хүснэгт №13 Зарлагын харьцуулалт /сая төгрөг /

| **№** | **Байгууллагын нэр** | 2024 оны орон нутгаас хүргүүлсэн төсвийн санал | 2024 он санал Сангийн Яам хянасан | Аймгийн ИТХ-аар батлуулах | Зөрүү /3-4/ |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **1** | Аймгийн ИТХ /ГХУСЗ-тай / | 848.2 | 674.7 | 753.2 | 78.5 |
| **2** | Сумдын ИТХ | 3,437.1 | 3,744.0 | 3,744.0 | - |
| **3** | Аймгийн ЗДТГ /ЗДНХ-тэй/ | 3,026.6 | 8,515.5 | 5,170.8 | (3,344.7) |
| **4** | Сумдын ЗДТГ | 17,253.8 | 15,726.2 | 17,094.4 | 1,368.2 |
| **5** | Хот тохижилт үйлчилгээний газар | 1,830.6 | 733.7 | 994.7 | 261.0 |
| **6** | Ойн анги | 466.8 | 563.3 | 563.3 | - |
| **7** | Байгаль орчин аялал жуулчлалын газар | 1,779.4 | 1,778.9 | 1,782.6 | 3.7 |
| **8** | Санхүүгийн хяналт, аудитын алба | 428.1 | 333.7 | 429.7 | 96.0 |
| **9** | Орон нутгийн эмчийн газар | 399.9 | 312.4 | 317.0 | 4.6 |
| **10** | Халамжийн сан | 142.4 | 117.7 | 117.7 | - |
| **11** | Засаг даргын ерөнхий данс | 1,157.1 | 1,920.1 | 4,444.8 | 2,524.7 |
| **12** | Орон нутгийн авто замын сан | 1,082.0 | 1,157.6 | 1,157.6 | - |
| **13** | Их засвар | - | 3,508.3 | 3,508.3 | - |
| **14** | Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын ашиглалт, үйлчилгээ / Боловсрол, соёл, эрүүл мэнд/ | 14,474.3 | 12,927.4 | 12,927.4 | - |
| **15** | Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын ашиглалт, үйлчилгээ / орон нутгийн удирдлагын салбар / | | 1,218.9 | | (1,218.9) |
| **16** | Дамжуулан зээлийн хүүгийн төлбөр | | 508.7 | 508.7 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **17** | Мал хамгаалах сан | | | 40.0 | 40.0 |
| **18** | ХААГ | | | 306.9 | 306.9 |
| | ДҮН | **46,326.3** | **53,741.1** | **53,861.1** | 120.0 |

Сангийн Яамнаас хянасан төсвийн зардлыг аймгийн ИТХ-аар батлуулах төсвийн төсөлд дараах өөрчлөлтүүдийг хийж хуваарилсан байна. Үүнд:

Хүснэгт№14 Төсөвт байгууллагуудад хуваарилсан байдал сая төгрөг

| **Зардлууд** | **Аймгийн ИТХ** | **Аймгийн ЗДТГ** | **Сумын ЗДТГ** | **БОАЖГ** | **СХАА** | **ОНӨГ** | **ХААГ** | **ХТҮГ** | **Мал хамгаалах сан** | **Засаг даргын ерөнхий данс** | **Төрийн эмчийн байр ашиглалт үйлчилгээ** | **Төсвийн урьд оны үлдэгдэл** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн нэмэгдэл** | 43.0 | (277.0) | | 167.4 | 25.1 | 21.0 | 20.5 | | | | | |
| **Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж** | 35.5 | (375.7) | | 208.1 | 70.9 | 30.3 | 30.9 | | | | | |
| **Засаг даргын нөөц хөрөнгө** | | (220.0) | 220.0 | | | | | | | | | |
| **Баяр наадмын зардал** | | (95.0) | 95.0 | | | | | | | | | |
| **Тогтмол зардал** | | 276.5 | 942.4 | | | | | | | | (1,218.9) | |
| **Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардал** | | | 371.8 | (371.8) | | | | | | | | |
| **Хөтөлбөр хэрэгжүүлэх зардал** | | (2,733.5) | | | | | 208.8 | | | 2,524.7 | | |
| **Цэргийн дүйцүүлэх албаны зардал** | | 80.0 | | | | | | | | | | (80.0) |
| **Хог хаягдал зайлуулах зардал** | | | (261.0) | | | | | 261.0 | | | | |
| **ОНӨГ-аас ХААГ-т шилжүүлэх зардал** | | | | | | (46.7) | 46.7 | | | | | |
| **Мал хамгаалах сангийн зардал** | | | | | | | | | 40.0 | | | (40.0) |
| **Нийт нэмэгдсэн, хасагдсан дүн** | **78.5** | **(3,344.7)** | **1,368.2** | **3.7** | **96.0** | **4.6** | **306.9** | **261.0** | **40.0** | **2,524.7** | **(1,218.9)** | **(120.0)** |

Засаг даргын ерөнхий дансанд хуваарилсан хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 1,100.0 сая төгрөг, Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд 660.0 сая төгрөг, Монгол Улсын болон аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө, Сайд нартай хамтран ажиллах гэрээний үүргийг хэрэгжүүлэхэд 464.7 сая төгрөг нийт 2,224.7 сая төгрөгөөр төлөвлөсөн нь хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтээр төлөвлөгдөөгүй, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулах эрсдэлийг бий болгож болзошгүй байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДСАН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТИЙН 81.6 ХУВЬ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА

*Г.4.1 Сангийн Яамнаас орон нутгийн 2024 оны төсвийн төслийг хянахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлуудыг бууруулан хянасан байна*

Орон нутгийн 2024 оны төсвийн урсгал зардлын саналд тавилга эд хогшил бэлтгэх зардалд 8.3 сая төгрөг төлөвлөснийг 100%, ном хэвлэлийн зардалд 44.4 сая төгрөг төлөвлөснийг 98.9%, багаж техник хэрэгслийн зардалд 299.5 сая төгрөг төлөвлөснийг 62.3% -аар тус тус бууруулан Сангийн Яамнаас Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцүүлж хянасан байна.

Мөн бусад зардлуудаас бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, нормын хувцас зөөлөн эдлэл, багаж техник хэрэгсэл, урсгал засвар, дотоод албан томилолт, бараа үйлчилгээний бусад зардал, нэг удаагийн тэтгэмж урамшуулал зэрэг бусад зардлуудыг 30-87 хүртэл хувиар бууруулан хянажээ. /Дэлгэрэнгүй судалгааг хавсралт №4-ээс үзнэ үү/

*Г.4.2 Аймгийн 2024 төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжих дүнгийн 81.6%-тай тэнцэх төсөл арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангасан байна.*

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд аймгийн ОНХС, авто замын сан, ОНТХО-ын эх үүсвэрээс санхүүжүүлэх нийт 13,732.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 57 төсөл, арга хэмжээг 11,184.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна. Төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №15 Төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл /сая төгрөг/

| Ангилал | | Хөрөнгө оруулалтын ангилал | | | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| | | Аймгийн ОНХСан | Авто замын сан | Аймгийн ОНТХО | |
| **Барилга байгууламж** | Тоо | 8 | | | **8** |
| | Төсөвт өртөг | 2,519.0 | | | **2,519.0** |
| | Санхүүжих дүн | 1,720.0 | | | **1,720.0** |
| **Их засвар** | Тоо | 5 | 1 | 17 | **23** |
| | Төсөвт өртөг | 895.2 | 1,157.6 | 4,917.4 | **6,970.2** |
| | Санхүүжих дүн | 605.2 | 1,157.6 | 3,458.3 | **5,221.1** |
| **Тоног төхөөрөмж** | Тоо | 14 | | | **14** |
| | Төсөвт өртөг | 2,668.6 | | | **2,668.6** |
| | Санхүүжих дүн | 2,668.6 | | | **2,668.6** |
| **ТЭЗҮ** | Тоо | 3 | | 1 | **4** |
| | Төсөвт өртөг | 460.1 | | 50.0 | **510.1** |
| | Санхүүжих дүн | 460.1 | | 50.0 | **510.1** |
| **Бусад** | Тоо | 3 | | | **3** |
| | Төсөвт өртөг | 1,065.0 | | | **1,065.0** |
| | Санхүүжих дүн | 1,065.0 | | | **1,065.0** |
| **Нийт ТАХ** | **Тоо** | **33** | **1** | **18** | **52** |
| | **Төсөвт өртөг** | **7,607.9** | **1,157.6** | **4,967.4** | **13,732.9** |
| | **Санхүүжих дүн** | **6,518.9** | **1,157.6** | **3,508.3** | **11,184.8** |

Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний мэдээлэл

Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр тусгасан 11,184.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 57 төсөл, арга хэмжээний 14 хувь нь барилга байгууламж, 49.1 хувь нь их засварын ажил, 24.6 хувь нь тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлэх, 7 хувь нь ТЭЗҮ, зураг төсөв, 5.2 хувь нь бусад хөрөнгө оруулалтын ажлууд байна.

Дүрслэл№4




Аймгийн 2024 оны төсвийн төсөлд тусгасан нийт хөрөнгө оруулалтын 58.3% буюу 33 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн 6,518.9 сая төгрөгөөр,10.3 хувь буюу нэг арга хэмжээг авто замын сангийн 1,157.6 сая төгрөгөөр, 31.4 хувь буюу 23 төсөл, арга хэмжээг аймгийн ОНТХО-ын 3,508.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус тусгажээ.

Дээрх 57 төсөл арга хэмжээ нь *“Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө”*-тэй уялдсан байна.

Хүснэгт№16 Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал

| Хөрөнгө оруулалт | Нийт ТАХ-ний тоо | Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал | | |
|---|---|---|---|---|
| | | Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл | Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр | Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө |
| **Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт** | 23 | 23 | 23 | 23 |
| **Аймгийн орон нутгийн хөгжлийн сан** | 33 | 12 | 33 | 33 |
| **Авто замын сан** | 1 | 1 | 1 | 1 |

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд тусгасан 11,184.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 57 төсөл, арга хэмжээг төсөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг шалгахад авто замын сангийн 1,157.6 сая төгрөгийн нэг, орон нутгийн хөгжлийн сангийн 900.0 сая төгрөгийн гурав, нийт 2,057.6 сая төгрөгийн дөрвөн ТАХ нь ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөвгүй, хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргаагүй байна.

Хүснэгт№17 Төсөвлөлтийн шаардлага хангасан эсэх мэдээлэл

/сая.төгрөг/

| Ангилал | Нийт ТАХ | | | Төсөвлөлтийн шаардлага хангаагүй | | | Санхүүжих дүнд харьцуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Төсөвт өртөг | Санхүүжих дүн | Тоо | Төсөвт өртөг | Санхүүжих дүн | |
| **Аймгийн ОНХСан** | 33 | 7,607.9 | 6,518.9 | 3 | 900.0 | 900.0 | 8.05 |
| **Авто замын сан** | 1 | 1,157.6 | 1,157.6 | 1 | 1,157.6 | 1,157.6 | 10.35 |
| **Аймгийн ОНТХО** | 23 | 4,967.4 | 3,508.3 | - | - | - | - |
| **Нийт** | 57 | 13,732.9 | 11,184.8 | 4 | 2,057.6 | 2,057.6 | 18.40 |

Дээрх хүснэгтээс харахад нийт санхүүжилтийн 81.6 хувь буюу 9,127.2 сая төгрөгийн 53 ТАХ нь төсөвлөлтийн шаардлага хангасан байна. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэрийн ангиллаар танилцуулбал:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайд:

Аймгийн Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу ГХБХБГ-аас 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн 18 сумын төсвийн байгууллагуудын 173 барилга байгууламжид үзлэг хийж нэгдсэн дүгнэлт, судалгаа гаргасан байна. Энэхүү судалгаа дүгнэлтэд үндэслэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, аргачлал”[1]-ын дагуу нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 4,967.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл, арга хэмжээг 3,508.3 сая төгрөгөөр санхүүжүүлэх жагсаалтыг боловсруулсан байна. Эдгээр төсөл арга хэмжээнд ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3[2] дахь заалттай нийцэж байна.

Аудитын явцад аймгийн Засаг даргаас анх ирүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалтад ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөвгүй арга хэмжээ тусгасан зөрчлийг таслан зогсоож, шинэчилсэн жагсаалтад тусгасан 23 төсөл, арга хэмжээ тус бүрийн ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсвийг гаргуулан авч зөрчлийг арилгууллаа.

- Аудитаар төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгаж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

2. Авто замын сангийн хөрөнгө оруулалтын тухайд:

Төсвийн төсөлд “Цэцэрлэг хотын төв доторх хатуу хучилттай авто зам, засвар арчлалт, тохижилт” хийх 1,157.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээг тусгасан байна. Энэ нь Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4[3] дэх заалт, МУЗГ-ын 2019 оны 312 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх захирах зарцуулах журам”-ын 3.3[4] дахь заалттай нийцсэн хэдий ч ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөвгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4[5], Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3[6] дахь заалттай нийцэхгүй, төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй байна.

- Аудитаас Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу төсөвлөлтийн шаардлагыг хангуулж ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг боловсруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын тухайд:

[1] Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан
[2] техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”
[3] 24.4. Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжид санхүүжүүлнэ.
[4] Гэнэтийн хүчин зүйл буюу байгалийн гамшигт үзэгдэл, осол болсны улмаас авто зам, замын байгууламжид эвдрэл, гэмтэл үүссэний улмаас авто замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх боломжгүй болсон тохиолдолд сэргээн засварлахад шаардагдах зардлыг авто замын сангийн тухайн жилийн төсвөөс тэргүүн ээлжид санхүүжүүлнэ.
[5] Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.
[6] техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн дагуу эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хүрээнд зохион байгуулсан форумаас гарсан санал, 19 сумын ЗДТГ, төсөвт байгууллагуудын төсөв захирагчид болон аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөөс ирүүлсэн саналыг нэгтгэж жагсаалт боловсруулсан байна. Энэхүү жагсаалтыг иргэдэд цахимаар танилцуулж давхардсан тоогоор 620 иргэнээс санал авч, хамгийн олон санал авсан 7,607.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл, арга хэмжээг 6,518.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс 13 нь барилга байгууламж, их засварын, 14 нь тоног төхөөрөмжийн, 3 нь ТЭЗҮ, 3 нь бусад ангилалд хамаарах хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ байна. Барилга байгууламж, их засварын 13 төсөл, арга хэмжээний 3 нь ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөв эцэслэн боловсруулагдаагүй, хөрөнгийн ашиглалтын урсгал зардлын тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт№18 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ

/сая төгрөг/

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр, байршил | Эхлэх/дуусах хугацаа | Төсөвт өртөг /сая.төг/ | Санхүүжүүлэх дүн /сая.төг/ | Ангилал | Ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулагдсан эсэх |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Малчдын өвс, тэжээлийн агуулах, саравч барих (Хашаат, Өндөр-Улаан, Ихтамир, Булган сум) | 2024 | 280.00 | 280.00 | Барилга байгууламж | Үгүй |
| 2 | Аймгийн хог хаягдлын цэгийг цэгцлэх | 2024 | 500.00 | 500.00 | Барилга байгууламж | Үгүй |
| 3 | Өндөр-улаан сумын 420 хүүхдийн хичээлийн байрны засвар | 2024 | 120.00 | 120.00 | Их засвар | үгүй |
| **Нийт дүн** | | | **900.00** | **900.00** | | |

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3[7], Сангийн Сайдын 2021 оны "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.1.3[8], 4.1.6[9] дах заалттай нийцэхгүй байна.

Аудитаас аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3 төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлагыг хангаж ажлын даалгавар,техникийн тодорхойлолт, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах, хөрөнгийн ашиглалтын урсгал зардлын үр ашгийг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

Аудитын явцад 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр ажлын даалгавар, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг тусгасан зөрчлийг таслан зогсоож, шинэчилсэн жагсаалтад тусгасан 33 төсөл, арга хэмжээ тус бүрээр ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсөв боловсруулсан материалыг гаргуулан авч зөрчлийг арилгууллаа.

[7] техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”

[8] ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх

[9] Аймаг, нийслэлийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргасан байх

## ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 75.7 ХУВЬ БАЙНА

Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй. Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг батжуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын нэг үе шат юм.

Аймгийн 2023 оны төсвийн төслийн аудитаар аймгийн ИТХ-д 3 асуудал толилуулж, аймгийн Засаг даргад 7 зөвлөмж хүргүүлснээс 3 зөвлөмж нь хэрэгжих шатанд, 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэл 75.7 хувьтай байна.

Өмнөх онд “хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах журмыг хэрэгжүүлж орон нутгийн түвшинд баримтлах хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх” тухай зөвлөмжийн дагуу Аймгийн Засаг даргаас ГХБХБГ-т чиглэл өгч 2023 онд 18 сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй төрийн өмчийн ЕБС, цэцэрлэг, дотуур байр, Соёлын төв, ЭМТ, ЗДТГ-ын зориулалттай нийт 173 барилга байгууламжид үзлэг хийж нэгдсэн дүгнэлт, судалгааг боловсруулжээ. Үүний дүнд аймгийн хэмжээний барилга байгууламжийн нэгдсэн дүгнэлт, судалгаанд үндэслэн аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх их засварын ажлуудыг эрэмбэлэх арга хэмжээ авч хэрэгжилтийг бүрэн хангасан байна.

Харин “Орон нутгийн төсвийн төслийг Төсвийн тухай хууль, төсвийн төсөл боловсруулах журамд заасан шаардлага, шалгуурын дагуу иж бүрэн боловсруулж, холбогдох нотлох баримтын хамт Төрийн аудитын байгууллагад Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ирүүлэх”, “ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны үр дүнд, дүн шинжилгээ хийж, өөрийгөө санхүүжүүлэн, үр ашигтай ажиллах зарчим баримтлахад тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх” талаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар нийт 2,057.5 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнд 3 зөвлөмжийг хүргүүллээ.

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлсэд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.**

- ✓ **ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦСЭН БОЛОВЧ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛААГҮЙ БАЙНА**
- ✓ **ТӨСВИЙН ОРЛОГЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР БАТЛАГДСАН ХЭМЖЭЭНД ТӨЛӨВЛӨСӨН БӨГӨӨД ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА**
- ✓ **ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР БАТЛАГДСАН ХЭМЖЭЭНД ТӨСӨВ ЗАХИРАГЧ БҮРЭЭР ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА**
- ✓ **ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДСАН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТИЙН 81.6 ХУВЬ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА**
- ✓ **ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 75.7 ХУВЬ БАЙНА**

**АУДИТЫН ЯВЦАД ЦУГЛУУЛСАН НОТЛОХ ЗҮЙЛС БОЛОН АУДИТЫН ДҮНД ҮНДЭСЛЭН ДАРААХ САНАЛЫГ ХҮРГҮҮЛЖ БАЙНА.**

## ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмж өгч байна. Үүнд:

**Архангай аймгийн ИТХ-ын дарга Б.Батжаргалд**

1. Аймгийн тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 дэх хэсэгт заасан хугацаанд баталж байх

*2024 оны 10 дугаар сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.*

**Архангай аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмидад**

1. Авто замын сангийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх “Цэцэрлэг хотын төв доторх хатуу хучилттай авто зам, засвар арчлалт, тохижилт”-ын ажилд Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу төсөвлөлтийн шаардлагыг хангуулж ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг боловсруулсан байх
2. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Малчдын өвс, тэжээлийн агуулах, саравч барих” (Хашаат, Өндөр-Улаан, Ихтамир, Булган сум), “Аймгийн хог хаягдлын цэгийг цэгцлэх”, “Өндөр-улаан сумын 420 хүүхдийн хичээлийн байрны засвар”-ын ажлуудад зураг төсөв, ажлын даалгавар боловсруулах, ашиглалтын зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах

*2024 оны 03 дугаар сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.*

3. Төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн хуулийн

13 дугаар зүйлийн 13.3.3-д тус тус заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгаж байх

*2024 оны 11 дугаар сарын 20-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.*

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2023 оны 12 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

**АРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГА**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3231,
Цахим шуудан: arkhangai.gov@gmail.com,
Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2023.11.23 № 01/1750
танай 2023.11.21-ны № 340-т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх санал ирүүлснийг судалж холбогдох хэлтсүүдийн тооцоо судалгааг үндэслэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэцүүлэн дараах шийдвэрийг гаргалаа.

Цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татварыг 634.9 сая төгрөгөөр, төрийн өмчийг худалдан борлуулснаас орох орлогыг 42.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх саналыг хүлээн авч нэмэгдүүлэн тооцоо хийж, аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэх 2024 төсвийн төсөлд тусгалаа.

Харин хадгаламжийн хүүгийн орлого өмнөх болон тайлант жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр тасарч байгаа тул нэмэгдүүлэх боломжгүй байна.

А/аудитор Н. [illegible]
[illegible] 03/XII

Б.ЦЭРЭННАДМИД

6523500929

## БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ

АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 11 сарын 24 өдөр Дугаар А/40 Эрдэнэбулган сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасан бүрэн эрх, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар "Эрх үүрэг шилжүүлэх" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэх өгөх" аудитын тайланг баталгаажуулсугай

2. Аудитын тайланг аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг хугацаанд нь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг аудитын менежер (Д.Нэргүйбаатар)-д даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын баримтыг архивын нэгж болгож, архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Н.Алтантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

Хавсралт 1

## АРХАНГАЙ АЙМГИЙН ААНБ, ИРГЭДИЙН ХАДГАЛАМЖИЙН СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ХИЙСЭН ТАТВАРЫН ТООЦОО

| № | Сумын нэрс | Хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ /төгрөгөөр/ | | Нийт хадгаламжийн дүн / төгрөгөөр / | Хадгаламжийн хүүний жигнэсэн дундаж хувь хэмжээ | | Хадгаламжийн хүүний жигнэсэн дундаж хувь хэмжээгээр тооцсон дүн /төгрөгөөр/ | | Нийт хадгаламжийн хүүгийн орлогын дүн жигнэсэн дундаж хүүгийн хувь хэмжээгээр тооцсон дүнгээр /төгрөгөөр / | ХХОАТ / төгрөгөөр / |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хугацаатай хадгаламж | Хугацаагүй хадгаламж | | Хугацаатай хадгаламж | Хугацаагүй хадгаламж | Хугацаатай хадгаламж | Хугацаагүй хадгаламж | | |
| 1 | Эрдэнэбулган | 68,531,237,650 | 9,961,111,666 | 78,492,349,316 | 12.30% | 2.60% | 8,429,342,231 | 258,988,903 | 8,688,331,134 | 868,833,113 |
| 2 | Батцэнгэл | 4,948,541,125 | 739,298,306 | 5,687,839,431 | 12.30% | 2.60% | 608,670,558 | 19,221,756 | 627,892,314 | 62,789,231 |
| 3 | Жаргалант | 5,171,101,669 | 1,363,614,497 | 6,534,716,166 | 12.30% | 2.60% | 636,045,505 | 35,453,977 | 671,499,482 | 67,149,948 |
| 4 | Ихтамир | 3,102,674,942 | 711,659,365 | 3,814,334,307 | 12.30% | 2.60% | 381,629,018 | 18,503,143 | 400,132,161 | 40,013,216 |
| 5 | Өгийнуур | 2,167,045,134 | 520,121,060 | 2,687,166,194 | 12.30% | 2.60% | 266,546,551 | 13,523,148 | 280,069,699 | 28,006,970 |
| 6 | Өлзийт | 4,007,306,895 | 690,003,165 | 4,697,310,060 | 12.30% | 2.60% | 492,898,748 | 17,940,082 | 510,838,830 | 51,083,883 |
| 7 | Өндөр-Улаан | 5,363,558,563 | 926,791,671 | 6,290,350,234 | 12.30% | 2.60% | 659,717,703 | 24,096,583 | 683,814,287 | 68,381,429 |
| 8 | Тариат | 4,672,603,718 | 1,118,925,501 | 5,791,529,219 | 12.30% | 2.60% | 574,730,257 | 29,092,063 | 603,822,320 | 60,382,232 |
| 9 | Төвшрүүлэх | 2,061,100,349 | 464,568,381 | 2,525,668,730 | 12.30% | 2.60% | 253,515,343 | 12,078,778 | 265,594,121 | 26,559,412 |
| 10 | Хайрхан | 4,944,399,029 | 1,469,041,378 | 6,413,440,407 | 12.30% | 2.60% | 608,161,081 | 38,195,076 | 646,356,156 | 64,635,616 |
| 11 | Хангай | 3,046,363,381 | 336,044,537 | 3,382,407,918 | 12.30% | 2.60% | 374,702,696 | 8,737,158 | 383,439,854 | 38,343,985 |
| 12 | Хашаат | 3,258,297,748 | 538,125,222 | 3,796,422,970 | 12.30% | 2.60% | 400,770,623 | 13,991,256 | 414,761,879 | 41,476,188 |
| 13 | Хотонт | 4,478,656,201 | 674,330,634 | 5,152,986,835 | 12.30% | 2.60% | 550,874,713 | 17,532,596 | 568,407,309 | 56,840,731 |
| 14 | Цахир | 1,721,836,328 | 714,834,026 | 2,436,670,354 | 12.30% | 2.60% | 211,785,868 | 18,585,685 | 230,371,553 | 23,037,155 |
| 15 | Цэнхэр | 3,163,419,204 | 1,103,300,251 | 4,266,719,455 | 12.30% | 2.60% | 389,100,562 | 28,685,807 | 417,786,369 | 41,778,637 |
| 16 | Цэцэрлэг | 5,058,173,546 | 1,190,227,804 | 6,248,401,350 | 12.30% | 2.60% | 622,155,346 | 30,945,923 | 653,101,269 | 65,310,127 |
| 17 | Чулуут | 3,321,231,100 | 851,335,592 | 4,172,566,692 | 12.30% | 2.60% | 408,511,425 | 22,134,725 | 430,646,151 | 43,064,615 |
| 18 | Эрдэнэмандал | 7,926,897,538 | 2,133,865,209 | 10,060,762,747 | 12.30% | 2.60% | 975,008,397 | 55,480,495 | 1,030,488,893 | 103,048,889 |
| 19 | Булган | 1,937,311,021 | 374,881,781 | 2,312,192,802 | 12.30% | 2.60% | 238,289,256 | 9,746,926 | 248,036,182 | 24,803,618 |
| | **Нийт дүн** | **138,881,755,141** | **25,882,080,046** | **164,763,835,187** | | | **17,082,455,882** | **672,934,081** | **17,755,389,964** | **1,775,538,996** |

Хавсралт 2

Орон нутгийн байгууллагуудын албан хаагчийн цалингийн өсөлтийн судалгаа /Засгийн Газрын 2022.12.28-ны өдрийн 488 дугаар тогтоол, 2022.03.09-ны өдрийн 107 дугаар тогтоол болон 2023.06.21-ны өдрийн 241 дүгээр тогтоол хоорондын харьцуулсан судалгаа /

| Албан тушаалын зэрэглэл, ангилал | Засгийн Газрын 2022.12.28-ны өдрийн 488 дугаар тогтоолоор | Засгийн Газрын 2023.06.21-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор | Зөрүү | Өсөлтийн хувь |
|---|---|---|---|---|
| ТЗ-1 | 1,232,536 | 2,218,000 | 985,464 | 80.0 |
| ТЗ-2 | 1,211,164 | 1,974,000 | 762,836 | 63.0 |
| ТЗ-3 | 1,151,108 | 1,862,000 | 710,892 | 61.8 |
| ТЗ-4 | 1,088,657 | 1,757,000 | 668,343 | 61.4 |
| ТЗ-5 | 1,045,653 | 1,597,000 | 551,347 | 52.7 |
| ТЗ-6 | 1,002,648 | 1,452,000 | 449,352 | 44.8 |
| ТЗ-7 | 924,456 | 1,320,000 | 395,544 | 42.8 |
| ТЗ-8 | 853,375 | 1,200,000 | 346,625 | 40.6 |
| ТЗ-9 | 791,532 | 1,100,000 | 308,468 | 39.0 |
| ТЗ-10 | 717,662 | 1,000,000 | 282,338 | 39.3 |
| Өсөлтийн дундаж хувь | | | | **52.5** |

| Албан тушаалын зэрэглэл, ангилал | Засгийн Газрын 2022.12.28-ны өдрийн 488 дугаар тогтоолоор | Засгийн Газрын 2023.06.21-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор | Зөрүү | Өсөлтийн хувь |
|---|---|---|---|---|
| ТТ-1 | 1,509,000 | 1,877,000 | 368,000 | 24.4 |
| ТТ-2 | 1,452,000 | 1,788,000 | 336,000 | 23.1 |
| ТТ-3 | 1,401,000 | 1,703,000 | 302,000 | 21.6 |
| ТТ-4 | 1,250,000 | 1,622,000 | 372,000 | 29.8 |
| ТТ-5 | 1,130,000 | 1,544,000 | 414,000 | 36.6 |
| ТТ-6 | 972,300 | 1,471,000 | 498,700 | 51.3 |
| ТТ-7 | 932,389 | 1,401,000 | 468,611 | 50.3 |
| ТТ-8 | 897,200 | 1,334,000 | 436,800 | 48.7 |
| ТТ-9 | 861,887 | 1,271,000 | 409,113 | 47.5 |
| ТТ-10 | 827,968 | 1,210,000 | 382,032 | 46.1 |
| ТТ-11 | 776,260 | 1,100,000 | 323,740 | 41.7 |
| ТТ-12 | 746,085 | 1,000,000 | 253,915 | 34.0 |
| Өсөлтийн дундаж хувь | | | | **37.9** |

| Албан тушаалын зэрэглэл, ангилал | Засгийн Газрын 2022.12.28-ны өдрийн 488 дугаар тогтоолоор | Засгийн Газрын 2023.06.21-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор | Зөрүү | Өсөлтийн хувь |
|---|---|---|---|---|
| ТҮ-1 | 565,277 | 750,000 | 184,723 | 32.7 |
| ТҮ-2 | 593,190 | 788,000 | 194,810 | 32.8 |
| ТҮ-3 | 615,152 | 827,000 | 211,848 | 34.4 |
| ТҮ-4 | 638,212 | 868,000 | 229,788 | 36.0 |
| ТҮ-5 | 686,638 | 912,000 | 225,362 | 32.8 |
| ТҮ-6 | 766,540 | 1,003,000 | 236,460 | 30.8 |
| ТҮ-7 | 827,799 | 1,053,000 | 225,201 | 27.2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ТҮ-8 | 861,490 | 1,114,000 | 252,510 | 29.3 |
| ТҮ-9 | 967,621 | 1,225,000 | 257,379 | 26.6 |
| ТҮ-10 | 998,671 | 1,286,000 | 287,329 | 28.8 |
| ТҮ-11 | 1,007,226 | 1,351,000 | 343,774 | 34.1 |
| ТҮ-12 | 1,075,488 | 1,418,000 | 342,512 | 31.8 |
| Өсөлтийн дундаж хувь | | | | **31.5** |

| Албан тушаалын зэрэглэл, ангилал | Засгийн Газрын 2022.03.09-ны өдрийн 107 дугаар тогтоолоор | Засгийн Газрын 2023.06.21-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор | Зөрүү | Өсөлтийн хувь |
|---|---|---|---|---|
| ТҮБД-5 | 964,899 | 1,404,000 | 439,101 | 45.5 |
| ТҮБД-4 | 934,899 | 1,337,000 | 402,101 | 43.0 |
| ТҮБД-3 | 850,717 | 1,273,000 | 422,283 | 49.6 |
| ТҮБД-2 | 799,806 | 1,213,000 | 413,194 | 51.7 |
| ТҮБД-1 | 663,418 | 1,100,000 | 436,582 | 65.8 |
| Өсөлтийн дундаж хувь | | | | **51.1** |

| Албан тушаалын зэрэглэл, ангилал | Засгийн Газрын 2022.03.09-ны өдрийн 107 дугаар тогтоолоор | Засгийн Газрын 2023.06.21-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор | Зөрүү | Өсөлтийн хувь |
|---|---|---|---|---|
| ТҮЭМ-9 | 1,039,119 | 1,548,000 | 508,881 | 49.0 |
| ТҮЭМ-8 | 973,165 | 1,474,000 | 500,835 | 51.5 |
| ТҮЭМ-7 | 964,899 | 1,404,000 | 439,101 | 45.5 |
| ТҮЭМ-6 | 934,899 | 1,337,000 | 402,101 | 43.0 |
| ТҮЭМ-5 | 832,357 | 1,273,000 | 440,643 | 52.9 |
| ТҮЭМ-4 | 799,806 | 1,213,000 | 413,194 | 51.7 |
| ТҮЭМ-3 | 740,619 | 704,000 | (36,619) | -4.9 |
| ТҮЭМ-2 | 663,419 | 1,155,000 | 491,581 | 74.1 |
| ТҮЭМ-1 | 616,629 | 1,100,000 | 483,371 | 78.4 |
| Өсөлтийн дундаж хувь | | | | **49.0** |

| Албан тушаалын зэрэглэл, ангилал | Засгийн Газрын 2022.03.09-ны өдрийн 107 дугаар тогтоолоор | Засгийн Газрын 2023.06.21-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор | Зөрүү | Өсөлтийн хувь |
|---|---|---|---|---|
| ТУСУ-7 | 995,822 | 1,548,000 | 552,178 | 55.4 |
| ТУСУ-6 | 932,617 | 1,474,000 | 541,383 | 58.0 |
| ТУСУ-5 | 895,945 | 1,404,000 | 508,055 | 56.7 |
| ТУСУ-4 | 766,480 | 1,273,000 | 506,520 | 66.1 |
| ТУСУ-3 | 709,760 | 1,213,000 | 503,240 | 70.9 |
| ТУСУ-2 | 635,775 | 1,155,000 | 519,225 | 81.7 |
| ТУСУ-1 | 590,937 | 1,000,000 | 409,063 | 69.2 |
| Өсөлтийн дундаж хувь | | | | **65.4** |

Хавсралт 3

Цалин хөлсний орлогын албан татварын 2024 оны нэмэгдлийн тооцоо

сая төгрөг

| 2024 оны орон нутгийн орлогын төсвийн төсөлд тусгасан дүн | 2024 оны Төсвийн тухай хуулиар төрийн албан хаагчдын цалинг 2024.04.01-нээс нэмэгдүүлэх хувь | Нийт сар | Татвар тооцох сар | ХХОАТ-ын хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 8,623.7 | 10% | 12 | 8 | 574.9 |

Хавсралт 4

## Төсвийн зарлагын харьцуулсан судалгаа

| Ангилал | 2024 он төсвийн хязгаар | 2024 он төсвийн санал | 2024 он Сангийн Яам хянасан | Зөрүү |
|---|---|---|---|---|
| НИЙТ | 48,425,802.3 | 46,726,322.5 | 53,741,065.3 | 7,014,742.8 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 48,425,802.3 | 46,726,322.5 | 53,741,065.3 | 7,014,742.8 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 36,031,233.7 | 46,726,322.5 | 50,232,768.5 | 3,506,446.0 |
| БАРАА, ЇЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 33,140,559.4 | 44,784,990.8 | 47,123,797.8 | 2,338,807.0 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 13,321,950.2 | 19,557,234.5 | 20,153,183.4 | 595,948.9 |
| Їндсэн цалин | 8,315,536.4 | 10,840,632.4 | 9,411,537.2 | (1,429,095.2) |
| Нэмэгдэл | 4,145,565.8 | 7,746,561.7 | 9,227,538.1 | 1,480,976.4 |
| Унаа хоолны Хөнгөлөлт | 77,809.0 | 219,151.4 | 161,401.0 | (57,750.4) |
| Урамшуулал | 783,039.0 | 727,129.0 | 1,327,650.4 | 600,521.4 |
| Гэрээт ажлын цалин | - | 23,760.0 | 25,056.7 | 1,296.7 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,664,691.0 | 2,750,818.0 | 2,519,147.8 | (231,670.2) |
| Тэтгэврийн даатгал | 1,131,917.0 | 1,870,556.1 | 1,713,020.7 | (157,535.4) |
| Тэтгэмжийн даатгал | 133,166.0 | 220,065.4 | 201,531.8 | (18,533.6) |
| ЇОМШ-ний даатгал | 106,533.8 | 176,052.5 | 161,225.3 | (14,827.2) |
| Ажилгїйдлийн даатгал | 26,633.6 | 44,013.1 | 40,306.3 | (3,706.8) |
| Эрїїл мэндийн даатгал | 266,440.0 | 440,130.9 | 403,063.7 | (37,067.2) |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,756,453.2 | 12,732,390.6 | 12,925,340.5 | 192,949.9 |
| Гэрэл, цахилгаан | 1,113,795.1 | 1,784,411.1 | 1,795,723.2 | 11,312.1 |
| Тїлш, халаалт | 8,866,444.9 | 9,869,195.9 | 10,098,086.0 | 228,890.1 |
| Цэвэр, бохир ус | 776,213.2 | 1,078,783.6 | 1,031,531.3 | (47,252.3) |
| Хангамж, бараа материалын зардал | 532,401.2 | 1,483,550.1 | 768,702.2 | (714,847.9) |
| Бичиг хэрэг | 55,900.0 | 273,036.4 | 92,553.4 | (180,483.0) |
| Тээвэр, шатахуун | 353,764.9 | 722,155.6 | 483,029.3 | (239,126.3) |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 78,960.1 | 169,877.5 | 103,719.9 | (66,157.6) |
| Ном, хэвлэл | - | 44,385.4 | 505.2 | (43,880.2) |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,150.0 | 169,571.1 | 8,456.3 | (161,114.8) |
| Бага їнэтэй, тїргэн элэгдэх, ахуйн эд зїйлс | 42,626.2 | 104,524.1 | 80,438.1 | (24,086.0) |
| Норматив зардал | 361,481.9 | 531,541.5 | 494,190.0 | (37,351.5) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 345,881.9 | 473,321.5 | 464,328.4 | (8,993.1) |
| Хоол, хїнс | 1,400.0 | 5,600.0 | 1,962.0 | (3,638.0) |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 14,200.0 | 52,620.0 | 27,899.6 | (24,720.4) |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 455,953.0 | 2,251,964.7 | 1,404,728.7 | (847,236.0) |
| Багаж, техник, хэрэгсэл | 67,735.2 | 299,475.0 | 112,661.5 | (186,813.5) |
| Тавилга | - | 8,300.0 | | (8,300.0) |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 120.0 | 6,270.0 | 6,150.9 | (119.1) |
| Урсгал засвар | 388,097.8 | 1,937,919.7 | 1,285,916.3 | (652,003.4) |
| Томилолт, зочны зардал | 156,238.3 | 484,921.2 | 283,253.9 | (201,667.3) |
| Дотоод албан томилолт | 156,238.3 | 484,921.2 | 283,253.9 | (201,667.3) |
| Бусдаар гїйцэтгїїлсэн ажил, їйлчилгээний төлбөр, хураамж | 5,119,871.4 | 3,558,247.7 | 7,804,617.7 | 4,246,370.0 |
| Бусдаар гїйцэтгїїлсэн бусад нийтлэг ажил, їйлчилгээний төлбөр, хураамж | 5,046,674.6 | 3,437,730.5 | 7,690,985.9 | 4,253,255.4 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 24,833.7 | 18,006.0 | 18,198.7 | 192.7 |
| Даатгалын їйлчилгээ | 10,300.5 | 12,032.0 | 10,120.9 | (1,911.1) |
| Тээврийн хэрэгслийн татвар | 8,354.3 | 12,580.2 | 10,748.2 | (1,832.0) |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 3,026.1 | 4,051.0 | 3,182.2 | (868.8) |
| Мэдээллийн технологийн їйлчилгээ | 18,173.4 | 57,510.0 | 56,024.7 | (1,485.3) |
| Газрын төлбөр | 4,945.1 | 7,938.0 | 7,453.5 | (484.5) |
| Банк, санхїїгийн байгууллагын їйлчилгээний хураамж | 3,563.7 | 5,900.0 | 5,451.1 | (448.9) |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 2,500.0 | 2,452.5 | (47.5) |
| Бараа їйлчилгээний бусад зардал | 771,519.2 | 1,434,322.5 | 770,633.6 | (663,688.9) |
| Бараа їйлчилгээний бусад зардал | 366,201.7 | 983,814.2 | 663,646.5 | (320,167.7) |
| Хичээл їйлдвэрлэлийн дадлага хийх | 405,317.5 | 450,508.3 | 106,987.1 | (343,521.2) |
| Хїї | 2,495,914.8 | - | 508,672.2 | 508,672.2 |
| Дотоодын зээлийн їйлчилгээний төлбөр | 2,495,914.8 | - | 508,672.2 | 508,672.2 |
| Дотоодын зээлийн їйлчилгээний төлбөр | 2,495,914.8 | - | 508,672.2 | 508,672.2 |
| ТАТААС | 18,800.0 | 25,000.0 | 358,065.0 | 333,065.0 |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 18,800.0 | 25,000.0 | 358,065.0 | 333,065.0 |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 18,800.0 | 25,000.0 | 358,065.0 | 333,065.0 |
| УРСГАЛ ШИЛЖЇЛЭГ | 375,959.5 | 1,916,331.7 | 2,242,233.5 | 325,901.8 |
| Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 117,000.0 | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 117,000.0 | | |
| Бусад урсгал шилжїїлэг | 375,959.5 | 1,799,331.7 | 2,242,233.5 | 442,901.8 |
| Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 120,000.0 | 142,400.0 | 117,720.0 | (24,680.0) |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 206,320.8 | 327,855.7 | 319,952.6 | (7,903.1) |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс їзїїлэх дэмжлэг | - | 1,033,998.0 | 1,735,583.2 | 701,585.2 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 49,638.7 | 295,078.0 | 68,977.7 | (226,100.3) |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 12,394,568.6 | - | 3,508,296.8 | 3,508,296.8 |
| Барилга | - | | | |
| Их засвар | 1,654,148.4 | - | 3,508,296.8 | 3,508,296.8 |
| Бусад хөрөнгө | 10,740,420.2 | - | | |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | - | - | 0.0 | - |
| Эргэж төлөгдөх зээл | - | - | 0.0 | - |
| ЗАРДЛЫГ САНХЇЇЖЇЇЛЭХ ЭХ ЇЇСВЭР | 48,425,802.3 | 46,726,322.5 | 53,741,065.3 | 7,014,742.8 |
| Улсын төсвөөс санхїїжих | 48,402,302.3 | 46,726,322.5 | 53,722,565.3 | 6,996,242.8 |
| Улсын төсвөөс санхїїжих | 48,402,302.3 | 46,726,322.5 | 53,722,565.3 | 6,996,242.8 |
| Төсөвт байгууллагын їйл ажиллагаанаас | 23,500.0 | - | 18,500.0 | 18,500.0 |
| Їндсэн їйл ажиллагааны орлогоос санхїїжих | 18,000.0 | - | 13,000.0 | 13,000.0 |
| Туслах їйл ажиллагааны орлогоос санхїїжих | 5,500.0 | - | 5,500.0 | 5,500.0 |